

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ЦЕМЕНТ ШОХОЙН  
ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

**ТАНИЛЦСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН ДАРГА

/...../

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН

МЭРГЭЖИЛТЭН

/...../

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН  
ҮЙЛДВЭРИЙН ДАРГА



Д. ГАНБАТ

“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

Г. ХАНДСҮРЭН

2022 он

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮР ДҮН.....	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	13
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21
7. ДҮЙЦҮҮЛЭНХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	25
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	29
12. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	36
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	49
14. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	53
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДАЛ.....	57
16. ДҮГНЭЛТ.....	59
17. ХАВСРАЛТ.....	60

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цавын цемент шохойн үйлдвэрийн төслийг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04 дүгээр сарын 16-нд МАК Цемент ХХК нь байгуулагдсан.

**Байгаль орчны баримтлах зарчим:** МАК Цемент ХХК нь Монгол улсын байгаль орчны тухай хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөх төдийд хязгаарлагдах бус үндэсний тэргүүлэгч компани гэдэг утгаараа эх орноо хайрлах сэтгэлээр хандаж, байгаль эхийнхээ эд, эс бүхнийг анхааран арчилж, хамгаалан ажиллахыг хэрэгжүүлж буй төсөл, үйлдвэр уурхайнхаа бүхий л үйл ажиллагааны туршид мөрдлөг болгодог билээ. Мөн МАК Цемент ХХК нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах тал дээр өнөөдрийг хүртэл ихээхэн хэмжээний хөрөнгийг зарцуулан ажилласаар ирсэн бөгөөд цаашид улам сайжруулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Үүний нэг илрэл нь манай төрийн болон орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын тогтмол хийдэг шалгалт, үнэлгээ зэргээс гадна байгаль орчны чиглэлийн олон улсын өндөр шаардлага бүхий хөндлөнгийн байгууллагууд, компаниудын олон удаагийн шалгалт, судалгаагаар “Монголн Алт” (МАК) ХХК-ийн үйлдвэр уурхайнууд тогтмол “сайн” гэсэн үнэлгээ авдаг явдал юм.

“Монголын Алт” (МАК) ХХК нь уурхайн орчин дахь аливаа бүтээн байгуулалт, барилга байгууламж, үйлдвэрлэлийг өөрийн орны болон олон улсын стандартад нийцүүлэн, орчин үеийн дэвшилтэт технологиор, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн инженерингийн компаниудтай хамтран бүтээн байгуулж байна. Мөн тухайн газарт холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллахаас гадна байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэсээр ирлээ.

**Компанийн эрхэм зорилго:** Компанийн аливаа үйл ажиллагаа, үйлдвэрлэлээс байгаль орчинд үүсч болох нөлөөллийг хамгийн бага байлгаж улам бууруулах тал дээр нийт компанийн ажилчид анхааран ажиллах нь бидний нэн тэргүүний зорилго юм.

Баримтлах бодлого: “Монголын Алт” (МАК) ХХК нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:


- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;

- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

Хөх цавын цемент шохойн үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших бөгөөд МАК Цемент ХХК нь 152.4 га талбайг 60 жилийн хугацаатайгаар эзэмшдэг. Жилд 900'000.00 тн/жил чулуунцар буюу 1'000'000.00 тн цемент үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай хуурай аргын цементийн үйлдвэр юм.



Зураг 1. Үйлдвэрийн байршил



Зураг 2. Ерөнхий төлөвлөлтийн зураг

**Түүхий эд:** Цементийн үйлдвэрлэлд шаардлагатай үндсэн түүхий эд материалын орд газрын лицензийг МАК Цемент ХХК нь эзэмшдэг тул үйлдвэрийг хямд өртөгтэй түүхий эдээр хангаж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, улмаар зах зээлд хямд өртөгтэй цемент нийлүүлэх боломжтой.

**Төслийн суурилагдах хүчин чадал:**

- Хоногт 3000 тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 50 жил хангахуйц нөөцтэй Хөх цавын шохойн чулууны орд.
- Жилд 100'000 тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай шохойн үйлдвэр.
- Жилд 900'000 тн чулуунцар буюу 1'000'000 тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэр.

**Үндсэн тоног төхөөрөмжүүд:** Тус цементийн үйлдвэр нь Дани улсын FLSmith компанийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байгальд ээлтэй, хаягдалгүй, хуурай аргын хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологитой бүрэн автомат ажиллагаатай үйлдвэр юм. Түүхий эдийн бутлуур, силосууд, эргэх зуух, туузан дамжлагуудаас гарах тоосыг ханцуйт шүүлтүүр, цахилгаан шүүлтүүрээр тоосыг шүүн агаарыг цэвэршүүлнэ. Бутлууруудын бункер дээр мөн бороожуулагч суурилуулсан байна. Энэ нь мөн нойтон аргаар агаарыг цэвэршүүлэх юм. Зуухны яндан дээр хий хянагч мониторингийн системтэй. Үйлдвэрийн технологид ус хэрэглэхгүй хуурай аргаар үйлдвэрлэлтийг явуулна. Харин тоног төхөөрөмжид хөргөлтийн зориулалтаар усыг ашиглах бөгөөд уг усаа циклдэж дахин ашигладаг.

**Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд:**

- 450 тонн/цагийн хүчин чадалтай шохойн чулууны бутлуур
- 75 тонн/цагийн хүчин чадалтай шаврын бутлуур
- 100 тонн/цагийн хүчин чадалтай төмрийн хүдрийн бутлуур
- 120 тонн/цагийн хүчин чадалтай нүүрсний бутлуур
- 70 тонн/цагийн хүчин чадалтай гөлтгөний бутлуур
- 21 тонн/цагийн хүчин чадалтай нүүрсний тээрэм
- 225 тонн/цагийн хүчин чадалтай түүхий эдийн тээрэм
- 225 тонн/цагийн хүчин чадалтай цементийн тээрэм
- Хоногт 3000 тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай эргэх зуух
- 30000 тонны хүчин чадалтай шохойн чулууны агуулах
- 3000 тонны хүчин чадалтай нүүрсний агуулах
- 2 x 180 тонн/цагийн хүчин чадалтай савлах машин

**Үйлдвэрлэх цементийн марк:**

- OPC 42.5

- OPC 52.5
  - PC 52.5
  - PC 62.5

**Ажиллах хүчин:** Үйлдвэр 2022 онд 900.0 мян.тн цемент үйлдвэрлэхээр төлөвлөснөөс үйлдвэрийн технологи болон бусад шалтгаанаар үйл ажиллагаа доголдон 2022.10.01-ний өдрийн байдлаар 633.2 мян.тн цемент үйлдвэрлэсэн бөгөөд үйлдвэр уурхайд нийт 600 орчим ажилчид ажилласан.

***Үйлдвэрийн технологи үйл ажиллагаа:***


Цементийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох шохойн чулууг өөрийн орд болох Хөх цавын шохойн чулууны уурхайгаас тээвэрлэн шохойн чулууны бутлуурт хүлээн авч бутлана. Буталсан шохойн чулуугаа нуруулдагчийн тусламжтайгаар химийн найрлагаар нь жигдрүүлэн шохойн чулууны агуулахад нуруулдана. Химийн найрлагын хувьд анхан шатны жигдрүүлэлт хийгдсэн шохойн чулуу болон тохируулгын нэмэлтийн түүхий эд болох шавар, төмрийн хүдэр, гөлтгөнө нь тохируулсан орц нормоор тугнуурт тэжээгүүрээр хуваарилагдан туузан дамжлагаар зөөгдөн түүхий эдийн тээрэмд өгөгдөн нунтаглагдана. Технологийн шаардлагыг ханган нунтаглагдсан түүхий эдийн хольц холимогийн силосд хадгалагдана. Холимогийн силосд түүхий эдийн хольц нь химийн найрлагын хувьд эцсийн жигдрүүлэлт хийгдэнэ. Химийн найрлагаараа жигдэрсэн түүхий эдийн хольц урьдчилан халаагчид тэжээгдэнэ. Урьдчилан халаагчийн шохойжуулагчид түүхий эдийн хольц 900°C температурт задрах урвалд орж 5-р циклоноор дамжин эргэх зууханд тэжээгдэнэ. Чулуунцар үйлдвэрлэх технологийн процессын 60% нь урьдчилан халаагчид, 40% нь эргэх зууханд явагдана. Түлшинд Хөт болон Таван толгойн нүүрсийг ашиглана. Уурхайгаас тээвэрлэж ирсэн нүүрсийг нүүрсний бутлуурт бутлан нүүрсний агуулахад жигдрүүлэн нуруулдана. Нүүрсний агуулахаас хамагчийн тусламжтайгаар нүүрсийг хаман зөөвөрлөж нүүрсний тээрэмд тэжээнэ. Нүүрсний тээрэмд технологийн шаардлагад нийцүүлэн нунтаглаж нунтаг нүүрсний бункерээр дамжуулан шохойжуулагч болон эргэх зууханд шатаалтыг явуулна.

Ø4.35м\*51м урттай эргэх зууханд 1450°C-д шатааж чулуунцарыг үйлдвэрлэнэ. Эргэх зуухнаас 1300°C-тай гарах чулуунцар хөргүүрт 80°C болтол хөрч чулуунцарын силосд хадгалагдана. Чулуунцарын силосоос чулуунцар туузан дамжлагаар зөөгдөн гөлтгөнө болон нэмэлтийн түүхий эдтэй хамт цементийн тээрэмд тэжээгдэнэ.


Цементийн тээрмээс 110°C-д 3800см<sup>2</sup>/гр хүртэл хувийн гадаргуутай цемент нунтаглагдаж гарна. Цемент нь цементийн тээрмээс хийн шугамаар зөөгдөн 10000 тн

багтаамжтай 4 ш силост хадгалагдана. Цемент нь силосоос задгайгаар болон савлах машинаар савлагдан ачигддаг.

### Технологийн схем







Зураг 3. Технологийн схем

## 2. 2022 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бизнес төлөвлөгөө нь компанийн ашигт ажиллагаа, үр бүтээлтэй байдлыг хэмжих боломжийг бий болгож, удирдлагыг мэдээллээр хангах, гүйцэтгэлд дүгнэлт өгөх, цаашлаад КРІ урамшуулал олгох эсэхэд баримт болно.

2022 оны 1-9-р сард хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, Монгол улсын стандартын шаардлага хангасан **ОРС 42.5** портланд цемент 633.2 мян.тн-ыг үйлдвэрлэж (төлөвлөгөөний биелэлт 91%), 685.4 мян.тн (төлөвлөгөөний биелэлт 91%) цемент борлуулсан.

Мөн үйлдвэр нь 02 дугаар сарын 15-наас үйл ажиллагааг эхлүүлсэн ба 2022 оны 12 дугаар сарын 15 хүртэл ажиллахаар төлөвлөсөн. 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйлдвэр нийт 245 хоног ажилласан байна.

Хүснэгт 2.1. Цемент үйлдвэрлэл, борлуулалт, 2022

Сар	Үйлдвэрлэл	Төлөвлөгөө	Биелэлт
1 сар	-	-	-
2 сар	-	9,690.0	0%
3 сар	53,491.9	66,300.0	81%
4 сар	57,021.1	102,000.0	56%
5 сар	88,180.7	105,400.0	84%
6 сар	101,825.8	102,000.0	100%
7 сар	111,612.2	105,400.0	106%
8 сар	117,479.6	105,400.0	111%
9 сар	103,628.3	102,000.0	102%
<b>1-9 сарын гүйцэтгэл</b>	<b>633,239.6</b>	<b>698,190.0</b>	<b>91%</b>

График 1. Цемент үйлдвэрлэл, тн





График 2. Бүтээгдэхүүн борлуулалт, тн




### 3. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


Цемент шохой үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2022 онд боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт Мак Цемент ХХК-аас гадна Эко Хэлхээ ХХК-ны жонш баяжуулах үйлдвэр, нүүрс олборлож буй Чингэсийн хар алт, Штайнколе, Пауэрленд ХХК-ууд, төмрийн хүдэр олборлох МГМК ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Цемент шохой үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

#### Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:



#### Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:



### Усны чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:




### Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:



### Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл

Цемент шохойн үйлдвэрийн талбайд хамгийн ойр орших улсын тусгай хамгаалалттай газар бол Их нартын байгалийн нөөц газар 24 км, орон нутгийн хамгаалалттай газар Хөшөөгийн энгэр 11 км-т оршдог байна. Тиймээс үйлдвэрлэлийн явцад тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл байхгүй.



Зураг 4. Үйлдвэр орчмын тусгай хамгаалалттай газрууд

#### 4. ЦЕМЕНТ ШОХОЙН ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших Цемент шохойн үйлдвэрийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

*Хүснэгт 4.1 Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт*

Дд	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13	13	-
2	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3	3	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	-	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	-	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн	5	5	-
7	Хог хаягдлын менежмент	7	7	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	11	11	-
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	9	9	-
10	Олон нийгэд тайлагнах үйл ажиллагаа	3	3	-
	<b>Нийт</b>	<b>51</b>	<b>51</b>	<b>-</b>

2022 онд Цемент шохойн үйлдвэр нь Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал.

- Үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хавар, намрын тарилтаар нийт 3100 мод сөөг тарьж усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэсэн.
- Мод үржүүлгийн талбайд Сухай, Жигд, Бургас, Улиас, Гүйлс зэрэг модны 1200 ширхэг үрсэлгээг үр болон мөчрөөр тарьж ургуулав.
- Үйлдвэрийн процессийн үе шат дамжлагуудаас үүсч буй тоосжилтыг бууруулах зорилгоор тоос, сорогч цахилгаан шүүлтүүр болон ханцуйт уутан шүүлтүүрийг ашиглаж байна.
- Нөлөөллийн бүсийн малчин иргэдийн худгийн усны түвшинг хянах зорилготойгоор хөтөлбөр боловсруулан нийт 13 н айл өрхийн худгийг хэмжээд байна.
- Цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй ба гол сөрөг нөлөөллийг хянах зорилгоор агаарын чанар, газар доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 5.1 Үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
1	Хучилттай замаар тээвэрлэлт хийх, хучилтгүй замаар тээвэр хийх тохиолдолд машины хурдыг хязгаарлах	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн бүх машин механизмуудын хурдны хязгаарыг хянах зорилготойгоор GPS суурилуулан, тоосжилт үүсэхээс сэргийлэн ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
2	Агаарын чанарын хэмжилт, тоосны мониторингийн дүнг үндэслэн хүлцэх хэмжээнээс дээш гарсан үзүүлэлтийг бууруулах арга хэмжээ авах	Үйлдвэрийн хэмжээнд	Тайлант онд үйлдвэрийн төв цэг дээр тоосны хэмжилтийг тогтмол хийсэн бөгөөд тоосны концентрацийн энэ оны дундаж агуулга 35.5 мкг/м <sup>3</sup> байсан ба өнгөрсөн онд 55.5 мкг/м <sup>3</sup> байсан байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад өмнөх оны дундаж утгаас энэ онд 10% хувиар тоосжилт буурсан байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
3	Үйлдвэрийн яндангаас хаягдах бохирдуулагчид болон тоос тоосонцороос урьдчилан сэргийлэх	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн яндан болон шат дамжлагуудаас үүсэх тоосжилтыг хянаж, тоос сорогч цахилгаан болон ханцуйт уутан шүүлтүүрийг солиж байршуулсан.	1,900.0	Тухай бүрт
<b>Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
4	Технологийн зориулалтаар ашиглаж буй өөрийн худгуудын тоолууранд хяналт тавьж, сумын байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран усны хэрэглээг хянан бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах	Гүний худаг	Үйлдвэрийн ашиглалтын нийт 4 худгийн тоолуурийг Даланжаргалан сумын ЗДТГазраар хянуулан баталгаажуулж, бүртгэл хөтлөж байна.	1,000.0	Жилдээ Тухай бүр
5	Тоолуурын баталгаажуулалтын хугацаанд хяналт тавьж сунгуулах	Ашиглалтын 1 худаг	Тайлант онд ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар гаргасан 4-р худгийн тоолуурийг баталгаажуулсан.	495.0	Тоолуурийн баталгаажуулалт хийх
6	Үйлдвэрийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах	Үйлдвэр	Үйлдвэрийн технологиос гарсан хаягдал усыг цэвэршүүлэн ногоон байгууламж болон зам талбайн усалгаанд дахин ашиглаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ Тухай бүр
7	Шугам сүлжээний гэмтлийг засварлах, усны алдагдал бууруулах	Худагт	Шугам сүлжээ гэмтлийг өдөр тутамдаа байнгын хяналт шалгалт хийж, усны алдагдал үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ Тухай бүр

8	Ундны усыг цэнгэгжүүлж унд ахуйн хэрэгцээний усаар хангах	Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж	Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж горимын дагуу ажиллаж нийт 16,633.8 м <sup>3</sup> гүний ус цэнгэгжүүлж ахуйн усны хэрэглээнд нийлүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
9	Хаягдал усны гэрээ байгуулж, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах	Үйлдвэр	Манай компани “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Усны газраар хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, УГГХДТалын сав газрын захиргаанаар гэрээ байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Гэрээг байгуулж төлбөрийг цаг тухайд төлж барагдуулсан байх
<b>Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
10	Шатах тослох материалыг битүүмжлэлтэй саванд хадгалах	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн засварын төвөөс гарах шатах тослох материалыг 5 тн, 10 тн-ын ёнкост хадгалаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
11	Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах		Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалт зааварчилгааг орж ажилласан.	700.0	Жилдээ
12	Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох тохиолдолд бүртгэл хөтлөх		Үйлдвэрийн бүс дотор нийт 2 удаа газар хөндөж үерийн далан суваг болон дотоод спорт заал барих зорилгоор газар хөндсөн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
<b>Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
13	Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Орон нутгийн малчин өрхөд	Үйлдвэр, уурхайн нийт 14 н айл өрхөд өвс тэжээл тарааж өгсөн.	1,500.0	100 ширхэг өвс малчдад өгсөн байх
<b>Нийт зардал, мян.төг</b>				<b>5,595.0</b>	


\* Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

### 5.1.1 Хучилттай замаар тээвэрлэлт хийх, хучилтгүй замаар тээвэр хийх тохиолдолд машины хурдыг хязгаарлах

Үйлдвэрийн бүсэд олон салаа зам гаргахгүй байх, зөвхөн зөвшөөрөгдсөн зассан замаар тээвэрлэлт хийгдэж байна. Машин механизмуудын хурдыг хязгаарлах зорилгоор дотоод журамын дагуу “Гайхам” GPS хяналтын программ ашиглан тээврийн хэрэгслүүдэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Хурд хэтрүүлсэн жолооч нарт анхааруулга өгч ажилласан. Жишээ болгон шохойн чулуу тээврийн Хово 5, 6, 12 машинуудын хурд хэтрүүлэлтийн тайланг хавсралтаар орууллаа.

(Хавсралт 1. Хурд хэтрүүлэлтийн тайланг [ЭНД](#) дарж харна уу)

Хово #05 / 66-11 ТТА / 2022 оны 10-р сарын 17 06:00 - 2022 оны 10-р сарын 18 06:00



Зураг 5. Хурд хэтрүүлэлтийн хяналт хийж буй байдал

### 5.1.2 Агаарын чанарын хэмжилт, тоосны мониторингийн дүнг үндэслэн хүлцэх хэмжээнээс дээш гарсан үзүүлэлтийг бууруулах арга хэмжээ авах

Тайлант онд үйлдвэрийн төв цэг дээр тоосны хэмжилтийг тогтмол хийсэн бөгөөд тоосны концентрацийн энэ оны дундаж агуулга 35.5 мкг/м<sup>3</sup> байсан ба өнгөрсөн онд 55.5 мкг/м<sup>3</sup> байсан байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад өмнөх оны дундаж утгаас энэ онд 10% хувиар тоосжилт буурсан байна. Мөн тоосны үзүүлэлт их гарсан тохиолдолд усалгааг 7 хоногт 3 удаа тогтмол хийж гүйцэтгэсэн.



Зураг 6. Тоосны хэмжилтийн дүн болон усалгаа хийж буй зураг


### 5.1.3 Үйлдвэрийн яндангаас хаягдах бохирдуулагчид болон тоос тоосонцороос урьдчилан сэргийлэх

Цемент шохойн үйлдвэрийн бүх дамжлага тоос шүүх хэсгүүдэд Bag filter буюу ханцуйт филтр суурилагдсан байдаг бөгөөд нийт 4 төрлийн ханцуйт шүүлтүүрийн уутыг ашиглаж байна. 50 ширхэг ханцуйт шүүлтүүр Мөн Electrostatic precipitator буюу цахилгаан тоос шүүх байгууламж нь халуун материал сорох зориулалттай клинкер хөргүүрээс тоос сорох хэсэгт суурилагдсан байдаг.



Зураг 7. Ханцуйт уутан шүүлтүүр солиж буй байдал





Зураг 8. Үйлдвэрийн агаарын бохирдлыг бууруулах ханцуйт шүүлтүүрийн байрлал

#### 5.1.4 Технологийн зориулалтаар ашиглаж буй өөрийн худгуудын тоолууранд хяналт тавьж, сумын байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран усны хэрэглээг хянан бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах

Технологийн зориулалтаар ашиглаж буй өөрийн худгуудын тоолуурын бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж ажилласан. Усны эх үүсвэр дэх тоолууруудын заалтыг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГазрын орлогч дарга, үйлдвэрийн ус, дулааны инженер, байгаль орчны мэргэжилтнүүд хамтран сар бүрийн эцэст тэмдэглэн, хэрэглээг хянаж ажилладаг. Дорноговь аймгийн усны тоолуур суурилуулах, салгах эрх бүхий “Чандмань Илч” ХХК нь үйлдвэрийн 3 худаг болон засвар үйлчилгээний төвийн урд талын худгийн тоолууруудыг салгах, суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. (Хавсралт 2. Худгийн тоолуурын гэрчилгээ, заалт, тоолуур суурилуулах, салгасан ажлын актыг [ЭНД](#) дарж харна уу).




Зураг 9. “Чандмань Илч” ХХК тоолуур суурилуулж буй байдал



Зураг 10. Үйлдвэрийн ашиглалтын худгуудын харагдах байдал

### 5.1.5 Тоолуурын баталгаажуулалтын хугацаанд хяналт тавьж сунгуулах


Тайлант онд үйлдвэрийн засвар үйлчилгээний урд байрлах ногоон байгууламжийн зориулалт бүхий худгийн тоолуурыг мэргэжлийн байгууллага болох “Чандмань Илч” ХХК-ийн лабораторид баталгаажуулсан.



Зураг 11. Баталгаажуулсан тоолуурын гэрчилгээ

### 5.1.6 Үйлдвэрийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах

Ус цэвэршүүлэх байгууламжаас хаягдаж буй усыг зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг ба усны хэрэглээг тоолуурын заалтаар хянан ажилладаг. Мөн 2017-2021 оны хооронд нийт дахин ашигласан ус 81% тай байсан ба 2022 оны 10-р сарын байдлаар хаягдал усны зарцуулалт 15% тай байна. (Хавсралт 3. Ногоон байгууламжийн усалгааны зарцуулалтын бүртгэл 4-9-р сарыг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 12. Хаягдал усыг ногоон байгууламжийн усалгаанд ашигласан зарцуулалт

### 5.1.7 Шугам сүлжээний гэмтлийг засварлах, усны алдагдал бууруулах

Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний засвар үйлчилгээг тухай бүрд гүйцэтгэн ажилласан. Мөн ус хэмнэх зорилгоор ногоон байгууламжийн усалгаанд сүүлийн үеийн дуслын усалгааны системүүдээр ханган ажиллаж байна.



Зураг 13. Шугам сүлжээний засвар, угсралтын ажил гүйцэтгэж байгаа нь

### 5.1.8 Ундны усыг цэнгэгжүүлж унд ахуйн хэрэгцээний усаар хангах

ЦШҮ-ийн усан хангамжийн шугам сүлжээ, усны байгууламж нь бүрэн автомат ажиллагаатай бөгөөд Гүний худагаас 1000м<sup>3</sup> усыг нөөцлөн түүнээс ус цэвэршүүлэх байгууламжаар түүхий ус 70%-ийг цэвэршүүлэн унд ахуйд ашиглан, 30%-ийн хаягдал усыг технологи болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж үйлдвэрийн усны норм, хэрэглээнд хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 14. Ус цэвэршүүлэх байгууламж

### 5.1.9 Хаягдал усны гэрээ байгуулж, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах

Манай компани “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу бохир усыг хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугаманд “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал, ерөнхий шаардлага MNS4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар авч гэрээг байгуулав. (Хавсралт 4. Дүгнэлт зөвшөөрөл болон гэрээг [ЭНД](#) дарж харна уу)



Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дэх хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны гаргасан 2022.08.08-р сарын 08-ны өдрийн 08 дугаартай хаягдал ус хаах, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ажиллуулалчийг төлөөлж Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны Усны урсгал, чанар, экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Цэрэнжав овогтой Батцэнгэл, нөгөө талаас: Ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хам-уул дүүрэг, 1-р хороо-19-р хорооний "Монголын алт" ХХК-ийн төв байр-44, 8011476083 урсны бүртгэлийн гэрчилгээ, 5530574 регистрийн дугаартай "МАК Цемент" ХХК-ийн Хөх цэвэр цемент-шохойн үйлдвэрийн байгаль орчны менежментийн П.Очирдаваа нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр талнаар хариуцсан тооцооллын энэхүү гэрээг 1 л/с-ийн хугацаатай байгуулав.

Хаягдал усны цэвэрлэх станц  
 2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хурээгийн байртай орчин Усны чанар Хаягдал ус Ерөнхий шаваргад МНС 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.  
 2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулал бодисын хэмжээгээс хамааран 2-5 дахин шалтгаан өссөж хэлбэрээр тооцож төлнө.  
 2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны дань бохирдуулал бодист ногдож төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эцсийн сарын 20-ны өдрийн дотор харьяалах Татварын албанд төлнө.  
 Жинлэгдэх бодис: 16мэлл\*10°146м\*0,001°50төлөгч=8116.8  
 Органик бодис/XXX: 139мэлл\*10°146м\*0,001°50төлөгч=211544.1төг

Зураг 15. Хаягдал усны зөвшөөрөл

5.1.10 Шатах тослох материалыг битүүмжлэлтэй саванд хадгалах

Үйлдвэрийн шатахуун түгээх станц нь газар доор битүүмжлэлтэй байгуулагдсан бөгөөд түлшний машинаас техникүүдэд түлш олголт хийгддэг. Ашигласан тос маслыг зориулалтын саванд цуглуулж үйлдвэрийн үйл ажиллагаанд дахин ашиглаж байна.



Зураг 16. ШТС, түлшний машин болон ашигласан тос цуглуулах хэсэг

### 5.1.11 Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах

Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед бэлэн байдлыг хангах зорилгоор асгаралт үүсгэх эрсдэлтэй цэгүүдийг тодорхойлж тус цэгүүд дээр асгаралтын үед хэрэглэх багаж хэрэгсэл, сав зэргийг байрлуулан хаягжуулсан. Үйлдвэрийн засварын төвд асгаралтын үеийн бэлэн байдлыг хангах цэг байгуулсан. Мөн сар бүр ажлын байрны үзлэг хийж гарсан асгаралтуудыг журмын дагуу цэвэрлүүлж, хариу арга хэмжээг авч ажиллаж байна.



Зураг 17. Асгаралтын хариу арга хэмжээ

### 5.1.12 Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох тохиолдолд бүртгэл хөтлөх

Тайлант онд үйлдвэрийн бүс дотор 2 удаа газар хөндөлт хийгдсэн. Үүнд: Үер уснаас сэргийлэн 3 хэсэгт хурын ус зайлуулах систем хийгдэж зөвшөөрлийн хуудас хөтлөх ажлыг гүйцэтгэсэн. (Хавсралт 5. Газар хөндөх зөвшөөрлийн хуудасыг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 18. Үерийн далан хийсэн байдал

### 5.1.13 Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

Үйлдвэр, уурхайн нөлөөллийн бүсийн 14 малчин айл өрхөд 2022 оны 03-р сард нийт 100 боодол өвс хүлээлгэн өгсөн. (Хавсралт 6. Өвс хүлээлгэн өгсөн акт [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 19. Малчдад өвс өгч буй байдал

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	2017-2022 онд тарьсан мод сөөг, зүлэгний усалгаа арчилгааг тогтмол хийх	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн хэмжээнд нийт 51,877 ширхэг мод сөөг ургаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
2	Үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх		Хавар, намрын улиралд нийт 3100 ширхэг мод тарьж ургуулсан.	21,520.5	5, 10-р сард
3	Мод үржүүлгийн талбайд тарилт хийх		Сухай, Жигд, Бургас, Улиас, Гүйлс зэрэг модны 1200 ширхэг үрсэлгээг үр болон мөчрөөр тарьж ургуулав.	2,000.0	5, 10-р сар
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>23,520.5</b>	

### 6.1 2017-2022 онд тарьсан мод сөөг, зүлэгний усалгаа арчилгааг тогтмол хийх

Үйлдвэрийн нийт ногоон байгууламжийн талбайд дуслын усалгааны систем суурилуулсан бөгөөд ус цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усаар ногоон байгууламжийн усалгааг тогтмол гүйцэтгэж байна. Үйлдвэрийн нийт ногоон байгууламжийг хэсгүүдэд хуваарилан өгсөн бөгөөд хэсгүүд өөрийн хариуцсан талбайн ногоон байгууламжийн арчилгааг тогтмол хийсэн.

(Хавсралт 7. Ногоон байгууламжийн усалгаа, арчилгааны хуваарилалтыг [ЭНД](#) дарж харна уу)





Зураг 20. Ногоон байгууламжийн ургалтыг дэмжихээр зэрлэг өвсийг зулгааж цэвэрлэж буй байдал



Зураг 21. Усыг хэмнэх зорилгоор сүүлийн үеийн дуслын усалгааны систем, PE 50м тэй усалгааны шугам хоолой суурилуулж буй байдал



Зураг 22. Ногоон байгууламжийн усалгаа



Зураг 23. Үйлдвэрийн нийт мод бутыг органик нийлмэл бордоогоор бордоож буй байдал



Зураг 24. Зүлэг тэгшлэх, мод бут хэлбэржүүлэлт хийгдэж буй байдал

## 6.2 Үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтын ажил дууссан хэсгүүдэд ногоон байгууламжийг нэмж 2017-2022 онуудад өссөн дүнгээр 12 га талбайд нийт 56,580 орчим мод, сөөгийг арчлан ургуулж байна.

2022 онд үйлдвэрийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлын хүрээнд хавар 4-р сард талбайн хөрс боловсруулалт, нүх ухах ажил эхэлж 8 н байршилд 7 төрөл зүйлийн 2550 ш мод сөөг тарьж ургуулсан байна. Үүнд: Жигд-500 ш, Сухай – 250 ш, Улиас-350 ш, Хайлаас-1000 ш, Бургас-350 ш, Сөөгөн боролзгоно-50 ш, Тэхийн шээг-50 ш, зэрэг мод сөөг тарьж арчилгаа хамгаалалтыг хийж байна. Мөн 2022 оны 10-р сарын 10-нд бүх нийтийн мод тарих өдрөөр нөхөн тарилтаар үйлдвэрийн 3 н байршилд 5 төрөл зүйлийн 550 ширхэг мод сөөгийг мод үржүүлгийн талбайгаас шилжүүлэн тарилтыг хийсэн.



Зураг 25. Хөрс боловсруулалт, модны нүх ухах буй байдал



Зураг 26. Хаврын тарилт хийж буй байдал



### 6.3 Мод үржүүлгийн талбайд тарилт хийх

Бид компанийн мод үржүүлгийн талбайд говийн бүс нутагт дасан зохицсон, амьдрах чадвар өндөртэй мод сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлын суулгацыг бэлтгэх, биологийн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах зорилгоор 0.67 га талбайд 2021 оноос хойш хийж эхлээд байна.

2022 оны хавар талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхэлж 5 төрөл зүйлийн 1200 ш үр болон мөчирөөр тарьж ургуулсан. Үүнд: Жигд-200 ш, Сухай-100 ш, Бургас-500 ш, Гүйлс бортогонд-200 ш, Улиас-200 ш тус тус үржүүлэн арчилгаа хамгаалалтыг хийж байна. Мөн бидний онцгойлон үрслүүлэн ургуулж буй Жигд мод нь говь нутгийн экологийн тэнцлийг хадгалахад онцгой ач холбогдолтой ба байгалийн нөхцөлд сэргэн ургах чадвар багасч жил ирэх тусам цөөрч ховордож нэн ховор ургамлын жагсаалтанд орсон мод юм.



Зураг 27. Улиас мөчрөөр тарьж ургуулсан байдал



Зураг 28. Сухай мөчрөөр тарьж ургуулсан байдал



Зураг 29. Жигд модыг үрээр гадаад талбайд тарьж ургуулсан байдал



Зураг 30. Намрын тарилтаар Гүйлс модыг үрээр тарьж буй байдал

## **7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төсөл нь барилгын материалын үйлдвэр учраас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.6 заалтын дагуу хамааралгүй байна.

## **8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөх цав барилгын материалын үйлдвэр төсөл нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Олон овоот багаас баруун урд 500м зайд байрлах ба үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн тус сууринд нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж БОННУ-д дүгнэсэн.

## **9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Үйлдвэрийн талбайн барилгын ажил эхлэхээс өмнө Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу 2012 оны 6 дугаар сард Монгол улсын шинжлэх ухааны академиар археологи, палеонтологийн хайгуулын судалгааны ажлыг хийлгүүлсэн. Уг судалгаа, ажиглалтын үр дүнд эртний амьтан, ургамлын үлдвэр илрээгүй гэсэн дүгнэлт гарсан. 2022 оны байдлаар барилгын болон газар шорооны ажил 100%, тоног төхөөрөмжийн угсралтын ажил 100%, барилгын металл хийцийн угсралтын ажил 100 %-тай хийгдсэн. Уг ажлыг гүйцэтгэх явцад археологи болон палеонтологийн олдвор олноогүй байна. (Эх сурвалж: Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн “Цемент шохойн үйлдвэрийн талбайд хийсэн археологийн судалгаа”-аар уг талбайгаас археологийн дурсгал олноогүй болно). Цаашид ч тохиолдох магадлал багатай ба түүх, соёлын дурсгалд үзүүлэх нөлөөлөл байхгүй байна.

Байгаль орчны багц сургалтын хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгал, олдворууд олдсон тохиолдолд дотооддоо боловсруулж батлуулсан “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу арга хэмжээ авах талаар сургалтыг нийт ажилтнуудад Байгаль орчны багц сургалтаар танилцуулан явуулсан.


## 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Нийт ажилтан	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн давхан зааварчилгаанд нийт 3189 ажилтан хамрагдсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
2	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
3	Сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн цэгт хадгалж байх	Лабораторийн ажилтан	Химийн сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн цэгт хадгалж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
4	Урьдчилан сэргийлэх үзлэг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	Нийт ажилтан	Үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг хяналт шалгалтыг өдөр бүр хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
5	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын иж бүрэн багаж суурилуулах	Үйлдвэрийн хэмжээнд	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт зааварчилгаа орж, галын иж бүрэн хэрэгслийг суурилуулсан.	500,000	Жилдээ
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>500.0</b>	

### 10.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах

МАК Цемент ХХК нь 2022 онд ISO 45001:2015 ХЭМАБ-ийн олон улсын стандартыг нэвтэрүүлэхээр ажиллаж байна. Уг ажлын хүрээнд нийт ажилчдад ХЭМАБ, БО-н сургалт, зааварчилгыг орж ажилласан.


График 3. 2022 оны сургалтын дүн



Зураг 31. Ажилтнуудад сургалт явуулж буй байдал

### 10.2. Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах

Ажилчдыг хөдөлмөр хамгааллын чанартай хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна. 2022.10.31-ний байдлаар тайлант онд зуны хувцас 559 ширхэг, өвлийн хувцас 404 ширхэгийг ажилтнуудад олгогдсон байна.



Зураг 32. Зуны хувцасны загвар

### 10.3. Сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн цэгт хадгалж байх

“МАК Цемент” ХХК-нь MNS 6458:2014 стандартад нийцсэн химийн бодис хадгалах зориулалттай агуулахын барилга угсралтыг ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байгуулсан. Химийн бодисын агуулахад хуурай бодисыг хадгалах төмөр шүүгээ 3 ширхэг, бодисын тавиур 4 ширхэг, байрлуулан бодис хадгалж буй өрөөнүүдийн тохижилтыг сайжруулах ажлыг гүйцэтгэв.



Зураг 33. Химийн бодисын агуулахад байрлуулсан зориулалтын хэрэглэгдэхүүнүүд

#### 10.3.1 Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах

Химийн бодисын сав баглаа боодол устгуулах нэмэлт гэрээг аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанаас гарсан 250 гр-ийн хуванцар сав 141 ширхэг, 500 мл-ийн шилэн сав 46 ширхэг химийн бодисын хуванцар сав баглаа боодлыг гэрээт компанид хүргүүлэх, устгуулах ажлыг зохион байгуулсан.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАВДАРГА ХААГАХ АЖЛЫН ДАТВА

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр	Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр
МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК	МАК Цемент ХХК

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАВДАРГА ХААГАХ АЖЛЫН ДАТВА

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**


Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Ажилтай холбоотой өөрөөр хянасан үйлдвэр, байршил, үйлдвэрийн нэр: **МАК Цемент ХХК**

Зураг 34. Химийн бодисын сав боодлыг мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн баримт, гэрээ

#### 10.4. Урьдчилан сэргийлэх үзлэг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх

Үйлдвэр дээрх урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг өдөр бүр ХЭМАБ,БО хэсгээс зохион байгуулдаг. Аюулыг илрүүлэх, мэдээллэх хуудасаар тайлант онд 810 аюул илрүүлж, 801 аюулыг устгасан байна.



Зураг 35. Аюулыг илрүүлэх, мэдээллэх хуудас

#### 10.5. Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын иж бүрэн багаж суурилуулах

Гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэгийг өдөр тутам зохион байгуулан, хяналт тавьж ажилладаг. Үйлдвэрийн хэмжээнд 12 ширхэг галын сарайг шинэчлэн сайжруулсан. галын гидрантуудын ажиллагааг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангасан. Холбогдох ажилтнуудад сургалт орж ажиллуулах зарчмыг зааж өгсөн.



Зураг 36. Галын сарайнуудыг шинэчилсэн байдал



Зураг 37. Галын гидрантуудын ажиллагааг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангасан

## 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Үйлдвэрийн хог хаягдлын түр цэгт ахуйн хог хаягдлыг ангилан цуглуулж, Олон овоотын хог хаягдлын төвлөрсөн цэгт зөөх	Хог хаягдлын цэгт	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, бусад төрөлд багтах хаягдлыг гэрээний дагуу Олон овоотын хог хаягдлын цэгт зөөж хаясан.	Хог хаягдлын гэрээгээр	VII
2	Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр, хорт хийг бага байлгахын тулд хог хаягдлын түр цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх	Уурхайн хэмжээнд	Хог хаягдал түр хадгалах цэгт сард 3 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
3	Үйлдвэрийн орчны хог хаягдлын цэвэрлэгээг хуваарийн дагуу гүйцэтгэх		Бүх нийтийн их цэвэрлэгээг хуваарийн дагуу зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
4	Үйлдвэрийн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах		Үйлдвэрийн хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
5	Хоёрдогч түүхий эд эрхлэгч байгууллагад дахин ашиглах боломжтой хог хаягдлыг шилжүүлэх		Хуванцар савыг ангилан ялгаж ЭКО говь ХХК-д хүлээлгэн өгсөн.	300,000	Жилдээ
6	Аюултай хог хаягдал /хаягдал тос, масло гэх мэт/-ыг үйлдвэрт ашиглах		Ашигласан тос маслыг	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
7	Аюултай хог хаягдал /хаягдал тос, масло гэх мэт/-ыг мэргэжлийн байгууллагад өгөх		Машин техникийн тос тосолгооны материалын хаягдал тосыг цуглуулах нөөцлүүрт нийлүүлдэг бөгөөд Алтан оршихуй ХХК болон Монпители ойл ХХК-нд хүлээлгэн өгсөн.	2,250,000	Жилдээ
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>2,250.0</b>	

### 11.1 Үйлдвэрийн хог хаягдлын түр цэгт ахуйн хог хаягдлыг цуглуулан, Олон овоотын хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэх

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, бусад төрөлд багтах хог хаягдлыг ЗДТГазартай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу Олон овоотын хог хаягдлыг маршрутын дагуу зөөж байна.



Зураг 38. Хог хаягдлын тээвэрлэлтийн маршрут

### 11.2 Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр, хорт хийг бага байлгахын тулд хог хаягдлын түр цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх

Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр, хорт хийг бага байлгахын тулд хог хаягдлыг тухай бүрд нь зөөвөрлөн ажилласан бөгөөд үйлдвэрийн хог хаягдлын түр цэгт мэргэжлийн байгууллага болох “Сан хими” ХХК-аар ариутгал халдваргүйтгэлийг 2 удаа, дотооддоо 7 хоногт 2 удаа хийж анхааран ажилласан. (Хавсралт 8. “Сан хими” ариутгалын ажлын гэрээг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 39. Хогийн цэгт ариутгал хийлгэж байгаа нь

### 11.3. Үйлдвэрийн орчны хог хаягдлын цэвэрлэгээг хуваарийн дагуу гүйцэтгэх

Хог хаягдлын журамын дагуу ил задгай хог хаяхгүй байх талаар хэсэг нэгжүүдэд сургалт зааварчилгааг тогтмол орж, цэвэрлэгээний хуваарилалтын дагуу зам талбайд хийсч тарсан хогны цэвэрлэгээг сар бүр зохион байгуулж 16 удаа хийж нийт 6.4 т3 хогийг зайлуулсан байна. (Хавсралт 9. Хог хаягдал цэвэрлэх талбайн хуваарилалтыг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 40. Үйлдвэрийн талбайд болон ойр орчимд хог хаягдлын цэвэрлэгээ хийгдэж буй нь

#### 11.4 Үйлдвэрийн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах

Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлэн хогийн савыг үйлдвэрийн бүх хэсгүүдэд байршуулсан бөгөөд хогийн цэгийн дахивар ангилан ялгалтын хэсгийн тэмдэг тэмдэглэгээг шинэчилж сайжруулсан. Бусад дахин ашиглах боломжтой төмөр, поошиг, агаарын шүүр, тосны шүүр, мод, дугуй зэргийг ангилан ялгаж хог хаягдлын бүртгэлийг ERP мэдээллийн сан үүсгэн хөтөлж байна. (Хавсралт 10. Хог хаягдлын бүртгэлийг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 41. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг бүх объектод байрлуулсан



Зураг 42. Хогийн цэгийн дахивар ангилах талбайд тэмдэг тэмдэглэгээг шинэчилсэн байдал



Зураг 43. Дахин ашиглах боломжтой овор ихтэй хаягдлыг тусгайлан бэлтгэсэн талбайд цуглуулж буй байдал

##### 11.4.1 Агаарын шүүгч, тосны шүүрийг ангилан ялгах

Үйлдвэрийн засварын төвийн үйл ажиллагаанаас гардаг аюултай хог хаягдал болох агаар шүүгч, тосны шүүрийг ангилан ялгаж, агаар шүүгчний гаднах төмрөн торыг дахин ашиглан үйлдвэрийн ногоон байгууламж дахь модыг туулай болон мэрэгч амьтдаас хамгаалах 3 ширхэг тор хийж



байрлуулсан. Мөн тосны шүүрийн үлдэгдэл тосыг шүүж цэвэрлэн уг хаягдлыг дахин ашиглан уурхайн замын шон хийхэд ашигласан ба тайлант онд нийт 5 ширхэг аюулгүйн шон хийж шаардлагатай газруудад байрлуулсан.



Зураг 44. Хаягдал тосны шүүр, агаарын шүүрийг дахин ашигласан байдал

### 11.5. Хоёрдогч түүхий эд эрхлэгч байгууллагад дахин ашиглах боломжтой хог хаягдлыг шилжүүлэх, борлуулах

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, МОГ Пластик ХХК хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Дорноговь аймагт “ЭКО ГОВЬ” ХХК дахивар хаягдал бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2020 оны 7 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. “МАК Цемент” ХХК-ийн үйлдвэр, уурхайгаас гарсан 200 кг хуванцар савыг 2022 оны 9-р сард дахин боловсруулагч үйлдвэрт нийлүүлсэн. (Хавсралт 11. Дахивар хаягдал хүлээлгэн өгсөн актыг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 45. Хуванцар хаягдлыг “Эко говь” ХХК-д хүлээлгэн өгч буй байдал

### 11.5.1 Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх.

“МАК Цемент” ХХК-ийн үйл ажиллагаанаас модон материал, төмөр, дугуйн хаягдал их хэмжээгээр гардаг бөгөөд эдгээр хаягдлыг дахивар нөөц болгон орон нутгийн иргэдэд дахин ашиглуулах зорилгоор өгдөг бөгөөд тайлант онд төмөр 21.3 тн, мод 2 портер, 83 ширхэг дугуй, 177 ширхэг поошиг, 10250 ширхэг слипшитийг дахин ашиглуулах зорилгоор нутгийн иргэдэд өгсөн.

*Хүснэгт 1. Үйлдвэрийн эргэх зуухны доторлогооноос гарсан хаягдал тоосгыг иргэдэд дахин ашиглуулахаар өгсөн мэдээ*

№	Огноо	Нэр	Хүлээн авагч	Хэмжих нэгж	Нэгж үнэ
1	13-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	520
2	13-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	530
3	14-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	530
4	14-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	530
5	14-Aug	Хаягдал тоосго	Гэрэл-Цогт	ш	210
6	14-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	110
7	15-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	500
8	15-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	500
9	15-Aug	Хаягдал тоосго	Баяртогтох	ш	700
10	15-Aug	Хаягдал тоосго	Батболд	ш	2000
11	2-Sep	Хаягдал тоосго	Гансүх	ш	1500
12	4-Sep	Хаягдал тоосго	Гансүх	ш	1000
13	2-Sep	Хаягдал тоосго	Баянмөнх	ш	4600
14	5-Sep	Хаягдал тоосго	Даваасүрэн	ш	15000
15	6-Sep	Хаягдал тоосго	Эрдэнэбаяр	ш	1500
16	7-Sep	Хаягдал тоосго	Эрдэнэбаяр	ш	1500
17	8-Sep	Хаягдал тоосго	Эрдэнэбаяр	ш	1500
18	9-Sep	Хаягдал тоосго	Эрдэнэ-Очир	ш	300
19	26-Sep	Хаягдал тоосго	Бат-Эрдэнэ	ш	9150

*Хүснэгт 2. Хаягдал дугуйг иргэдэд дахин ашиглуулахаар өгсөн мэдээ*

№	Огноо	Нэр	Хүлээн авагч	Хэмжих нэгж	Нэгж үнэ
1	12-May	Хаягдал дугуй	Нэмэхжаргал	ш	20
2	12-May	Хаягдал дугуй	Нэмэхжаргал	ш	25
3	30-Jul	Хаягдал дугуй	Гансүх	ш	43
4	2-Sep	Хаягдал дугуй	Баянмөнх	ш	6
5	9-Sep	Хаягдал дугуй	Эрдэнэ-Очир	ш	1
6	9-Sep	Хаягдал дугуй	Эрдэнэ-Очир	ш	1
7	13-Sep	Хаягдал дугуй	Баасандорж	ш	7

Хүснэгт 3. Хаягдал төмөр, мод, пошиг, подооны суурь слипшитийг иргэдэд дахин ашиглуулахаар өгсөн мэдээ

№	Огноо	Нэр	Хүлээн авагч	Хэмжих нэгж	Нэгж үнэ
1	2-Apr	Хаягдал төмөр	Гансүх	кг	18000
2	12-Apr	Хаягдал төмөр	Гансүх	кг	300
3	26-May	Хаягдал мод	Бямбасүрэн	портер	1
